

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2020.12.17-ны өдрийн 09 дүгээр хуралдааны шийдвэрээс:

9.1. “Онцгой байдлын ерөнхий газрын стратеги төлөвлөгөө”-ний төслийн тухай хэлэлцээд Шадар сайдын ажлын албанд хүргүүлж, батлуулахаар шийдвэрлэв.

9.2. Гамшгийн үед иргэдийн түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршил, түр байрны заавар”-ын төслийн тухай хэлэлцээд дахин боловсруулалт хийхээр буцаав.

9.3. “Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүн газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах төлөвлөгөө”-ний төслийн тухай хэлэлцээд нарийвчлан боловсруулж, даргын зөвлөлийн гишүүдээс дахин санал авч нэгтгэн 12 дугаар сарын 25-ны дотор батлуулахыг даалгав.

9.4. Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд нэмэлт тодруулгыг авч нэгтгэн, 2021 оны 01 дүгээр сарын 05-ны дотор Шадар сайдын ажлын албанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

9.5. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тухай хэлэлцээд дүнг 100 хувийн үнэлгээтэй батлав.

9.6. Онцгой байдлын ерөнхий газарт гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд дүнг 76.0 хувийн үнэлгээтэй батлав.

9.7. “ОББ-ын албан хаагчдын мэргэшлийн зэргийн тэмдгийн загвар”, “Онцгой үйлстэн тэмдэг”, “Хүндэт тэмдэг”-ийн загварыг батлах тухай хэлэлцээд холбогдох засвар өөрчлөлтийг тусган зургаар танилцуулахыг даалгав.

---oOo---